

Дундговь аймгийн Засаг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдтай 2022 онд хамтран ажиллах гэрээний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан

2022.12.15

Аймгийн Засаг даргын Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг хийж, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл өгч ажилласан.


НЭГ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2-т заасан арга зүйгээр Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсээс ирүүлсэн тайланд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.


Засаг дарга хамтран ажиллах гэрээгээр 48 үүргийг хүлээж, жилийн эцсийн байдлаар 90.9 хувьтай хэрэгжүүлсэн байна.

ХОЁР.ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН АРГА ХЭМЖЭЭНҮҮДЭЭС ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ГЭЖ ҮЗЭВ.


Засгийн газрын 2022 оны 222 дугаар тогтоолын дагуу аймаг, сумдын мал аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах шалгуур үзүүлэлтийн дагуу Аймгийн Засаг даргын 10 сарын 17-ны өдрийн А/406 тоот захирамжаар өвөлжилтийн бэлтгэл хангалтын байдалтай танилцсан. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл 86,3 хувьтай хангагдсан нь урд оноос 6.2 хувиар ахисан үзүүлэлттэй байна.




Таваарын буюу хэрэгцээний 750915 малаас 498286 малыг зах зээлд борлуулж эдийн засгийн эргэлтэд оруулаад байна.



Төсөл хөтөлбөр, Орон нутгийн төсвийн 736,6 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан, Говь-Угтаал, Дэрэн, Луус, Өндөршил, Сайнцагаан, Хулд, Эрдэнэдалай сумдад инженерийн хийцтэй 25 худаг, Баянжаргалан, Дэрэн, Хулд, Эрдэнэдалай сумдад 27 цооногийг гаргаж бэлчээр усжуулалтыг 1,5 хувиар нэмэгдүүлсэн.



Хүний хөгжлийг дэмжих жил, Монгол малчин үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Малчдыг соён гэгээрүүлэх, мэдлэг мэдээллээр хангах ажлын хүрээнд малчдын зөвлөгөөнийг 15 суманд холбогдох байгууллагууд хамтран амжилттай зохион байгуулж, нийт 3626 малчин хамруулсан арга хэмжээ болсон.





Сайнцагаан сумын Сайнцагаан омгийн хонь, Өндөршил сумын Өндөршил омгийн адуу, Хулд сумын Олдохын хүрэн бор омгийн тэмээнд үзлэг ангилалт хийж малын Бүртгэл мэдээллийн нэгдсэн санд нийтдээ 6400 мал оруулсан.




Хээлтүүлгийн бус үед эх сүргээс нь ялган суурилсан хуц 6705, ухна 5358 бүгд 12063 хээлтүүлэгч ялган суурилсан. Ялгавал зохих хээлтүүлэгч малын 63 хувийг ялган суурилж өмнөх оноос 34 хувиар нэмэгдүүллээ.



Орон нутгийн хөгжлийн сан, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл 224,0 сая төгрөгийн санхүүжилтээр Баянжаргалан, Дэлгэрхангай, Өлзийт, Сайнцагаан, Хулд, Эрдэнэдалай сумдад инженерийн хийцтэй 7 худгийг шинээр гаргаж ашиглалтад оруулсан. 440,0 сая төгрөгийн санхүүжилтээр Аймгийн Засаг даргын өвс, тэжээлийн агуулахын барилгыг ашиглалтад оруулсан. Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах, зах зээлд зуучлах "Дундговьд үйлдвэрлэл" борлуулалтын төв шинээр ашиглалтад оруулж жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, идэвхжүүлэх, сурталчлах, тэдний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг шимтгэлгүйгээр борлуулах боломж бүрдэж өнөөгийн байдлаар 130 гаруй үйлдвэрлэгч бараа бүтээгдэхүүнээ дэлгэн 142,0 сая төгрөгийн борлуулалт хийжээ.




Мерит төсөлтэй хамтарсан ЖДҮҮЭ-ийг чадавхжуулах Модуль-3 сургалтад давхардсан 24 үйлдвэрлэгч, ХХҮГ-тай хамтарсан боловсруулсан арьс ширээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх сургалтад 20 гаруй үйлдвэрлэгчийг хамруулан сургалаа. Мөн орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг Төв аймгийн Баянчандмань сумын сүү, ногоо, тахиа, салфетканы үйлдвэрүүд болон Улаанбаатар хотын “Цэвэр хөрсний шим” дундын хоршооны мөн Хэнтий аймгийн Баян-Овоо, Түмэнцогт сумдад зохион байгуулагдсан аялалд 10 хүнийг хамруулж нийт 34 иргэнийг сургалтад хамрууллаа.




ЖДҮХС, ХХС-ийн хөнгөлөлттэй зээлээс 2022 онд нийт 18 төсөлд 1032,0 сая төгрөгийн зээлийг олгосон ба үүний үр дүнд шинээр 5 үйлдвэр, 37 ажлын байр бий болоод байна.

Жаргалант сор ХХК нь өндөгний “gobi” брэндийг үүсгэн, өндгөө зах зээлд нийлүүлж эхэллээ. Дундговьчууд эрүүл ахуйн шаардлага хангасан, шинэ өндгийг өдөр тутамдаа хэрэглэх боломж бүрдсэн.



Сумдын мэргэжилтнүүд болон давхардсан тоогоор нийт 1800 гаруй хоршоо, малчдын төлөөлөлд “Хоршооны тухай хуульд орсон гол өөрчлөлтүүд”, “Хоршооны тухай хууль, холбогдох журмын дагуу хоршоодыг шинэчлэн бүртгэх тухай”, “Хоршооны гишүүний болон сумын засаг даргын эрх, үүрэг, хариуцлага”, “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”, “Хоршооны дүрмийн өөрчлөлт, улсын шилдэг хоршоо шалгаруулах журам” зэрэг сэдвийн хүрээнд танилцуулга, мэдээлэл олгох 7 удаагийн арга хэмжээг зохион байгууллаа. Энэ онд нийт шинээр хоршоо байгуулахаар 10 гаруй иргэн мэргэжил арга зүйн, 5 хоршоо санхүүгийн дэмжлэгт хамрагдсан.





ДУТАГДАЛТАЙ ХЭРЭГЖСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Нийт 79 га-д талбайд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээлийн ургамал тариалахаар төлөвлөн ажилласан. Үүнээс: Аймгийн хэмжээнд 23 ААН, 153 иргэн 2022 онд нийт 71,9 га-д төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээлийн ургамал тариалж төлөвлөсөн хэмжээнээс талбайн хэмжээ 7.1 га-гаар буурч, талбай харьцуулалт 91 хувьтай байна. Ургац хураалтаар нийт 71,9 га-аас 423,2 тн-ийг хурааж, урьд онтой харьцуулахад 4.4 тн-оор нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа боловч тариалах талбай, хураан авах ургац, боловсруулах уриншийн төлөвлөгөөндөө хүрээгүй үзүүлэлттэй байна.

Төмсний үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх аймгийнхаа хэрэгцээг хангах арга хэмжээний хүрээнд төмс 29.4 га-аас 234.4 тн-ийг хураан авсан байгаа нь хураан авах ургацын хэмжээ нь зорилтот түвшиндээ хүрээгүй, мөн хүнсний ногоо хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, хүнсний ногооны тариалах талбайн хэмжээг сум бүрд 20 га-р нэмэгдүүлэх, шинээр газар эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээний хүнсний ногоо 21,5 га-аас 176,2 тн-ийг хураан авсан нь зорилтот түвшиндээ хүрээгүй.

ДӨРӨВ: ГЭРЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ


Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний Хүнс хөдөө аж ахуйн салбарын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг 90.9 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлж үнэлгээний саналыг хүргүүлж байна.


Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 3б хавсралтын дагуу оны эхэнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн төлөвлөлтийн шаардлагыг ханган томьёолж, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлон, суурь түвшин, хүрэх түвшнийг бодитой тооцон төлөвлөж батлуулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байх шаардлагатай байна.

Баталгаажуулсан:

Аймгийн Засаг дарга  Ц.Мөнхбат

Хянасан:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  Д.Даариймаа
Тайлан бичсэн:

Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн 

Э.Одончимэг